



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/226

Мөрөн

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.3-ын "а", 29.2, Төсвийн тухай хуулийн 14.2.5, Засгийн газрын 2011 оны 374 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Мал хамгаалах сангийн аюулгүйн нөөцөд байгаа задарсан өвсийг пресслэж бэлэн болгоход шаардагдах материал болон ажлын хөлс 1617,000 /Нэг сая зургаан зуун арван долоон мянган төгрөг/ өвс пресслэгчийн тээврийн хөлс болох 1200,000 /Нэг сая хоёр зуун мянган төгрөг /, нийт 2817,000 /Хоёр сая найман зуун арван долоон мянган төгрөг/-ийн зардлыг Мал хамгаалах сангийн бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас зарцуулахыг Мал хамгаалах сангийн нягтлан бодогч /Н.Аззаяа/-д зөвшөөрсүгэй.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Боож бэлтгэсэн өвсийг агуулах, саравчинд хураалгаж хадгалалт, хамгаалалтанд хяналт тавьж ажиллахыг Мал хамгаалах сангийн нягтлан бодогч Н.Аззаяа, нярав С.Зээхүү нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Аззаяа, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Г.Баттулга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД

Аймгийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр
сарын 19-ний өрийн А/227 дугаар
захирамжийн хавсралт

МХСАНГИЙН ЗАДАРСАН ӨВСИЙГ ПРЕССЛЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Материалын нэр	Тоо хэмжээ	Үнэ хөлс	Ажиллах өдөр	Нийт
1	Түлш	150	1980		297000
2	Мяндас	3	90000		270000
3	Өвс пресслэх ажилчидын хөлс	5	50000	3	750000
4	Пресслэсэн өвс хураах ажилчидын ажлын хөлс	30	10000	1	300000
5	Пресслэгчийн тээврийн хөлс				1200000
	Нийт				2817000